



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 1/21

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зардалд 6501000 / зургаан сая таван зуун нэг мянга / төгрөгийг зарцуулсугай.

2.Төрийн албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгийн зардалд зарцуулагдах 6501000 /зургаан сая таван зуун нэг мянга / төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч / Б.Нандин-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч / Б.Мягмаржав/-д үүрэг болгосугай.

ДАРГА
Н.ХАТАНБААТАР